Бараа материалын дансны үлдэгдэл 3,487,987.6 мянган төгрөг болж 272,665.6 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал 57,101.8 мянган төгрөгөөр буурч, бэлэн бүтээгдэхүүн 221,198.2 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 67,981.7 мянган төгрөг, бусад бараа материал 40,587.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс холбоотой байна.

Ковид-19 цар тахлын тархалт, нөхцөл байдлын улмаас тусгаарлан ажиглах, хэвтүүлэн эмчлэх бэлэн байдлыг хангах, үүний тулд эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай нэг удаагийн хамгаалах хувцас болон бусад эмнэлгийн хэрэгслийг 30 хоногийн нөөцтэйгээр бэлтгэсэн нь бараа материалын үлдэгдэл өсөх шалтгаан болжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 40,486,901.3 мянган төгрөг болж 2,937,998.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 805,243.1 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэн, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 204,761.8 мянган төгрөгийн хөрөнгө балансад балансад үнэ төлбөргүй шилжиж ирсэн, 80,000.0 мянган төгрөгийн программ хангамжийн ажлыг биет бус

хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 290 дүгээр тогтоолын дагуу 124,284.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устган, тайлант онд 3,903,718.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 52,005.0 мянган төгрөг болж 108,114.1 мянган төгрөгөөр буурсан нь 148,743.0 мянган төгрөгийн чанарын баталгааны барьцаа хөрөнгийг чөлөөлж, 41,515.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг өглөгийн дансанд бүртгэж, 886.1 мянган төгрөгийн бусад өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 99 хувь буюу 51,515.0 мянган төгрөг нь 2017-2020 онд бэлтгэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааны барьцаа хөрөнгө, 1 хувь буюу 490.0 мянган төгрөг нь Ай эм эс инженеринг ХХК-д төлөх гэрээт ажлын төлбөрийн зөрүүний үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансанд тайлант онд бүртгэлийн өөрчлөлт ороогүй бөгөөд 238,499.5 мянган төгрөг байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,702,037.9 мянган төгрөг буюу 23.3 хувиар өсөж, 14,312,972.8 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 785,622.1 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилт 1,086,429.4 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн орлого 1,700,679.2 мянган төгрөгөөр тус тус өссөн нь өмнөх оны орлогоос материаллаг хэмжээгээр өссөн байна.

Орлогын өсөлттэй уялдаж нийт зардал ба цэвэр зээлийн дүн өмнөх оноос 2,333,931.9 мянган төгрөгөөр буюу 16.3 хувиар өсөж 16,655,229.2 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 972,832.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 83,230.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 20,208.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 85,669.4 мянган төгрөг, нормативт зардал 388,240.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 94,182.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 66,108.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 789,798.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс албан хаагчдын үндсэн цалин нэмэгдсэн, Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2020 оны Н/118 тушаалаар төрийн тусгай албан хаагчид /эмч, сувилагч/-ын цалингийн зэрэглэлийг нэмэгдүүлсэн, нэн шаардлагатай 12 орон тоог бүрдүүлсэн зэрэг нь цалин хөлс ба нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өсгөх шалтгаан болжээ.

Тайлант онд өндөр өртөгт тусламж үйлчилгээний санхүүжилт болон үйлчлүүлэгчийн тоо өмнөх оноос нэмэгдсэн, дотоод гүйлгээгээр данслагдсан бага үнэтэй түргэн элэгдэх эд материалыг акталж данснаас хассан, урьд оны бараа материалын нөөцийн үлдэгдлээс зарцуулсан, өндөр өртөгт тусламж үйлчилгээний тоо хэмжээ өмнөх оноос өссөн зэрэг нь бараа үйлчилгээний зардал нэмэгдэх үндэслэл болсон байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 17,483,212.86 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 17,483,212.86 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг Сангийн яам хянаж батлахдаа төсвийн төслөөс 2,682,956.76 мянган төгрөгөөр бууруулж 14,800,256.1 мянган төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд суурилж, бодитой төлөвлөгдсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 14,800,256.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 4,475,261.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 9,104,307.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас 1,220,686.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,469,493.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 8,344,690.6 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,224,345.5 мянган төгрөгийг бүрдүүлж нийт 14,038,529.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 13,437,941.3 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвөөс зарцуулаагүй 372,019.0 мянга, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн үлдэгдэл 228,569.2 мянга нийт 600,588.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,437,941.3 мянган төгрөг буюу 90.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 372,156.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 71,524.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 13,007.1 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 3,978.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 86,344.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал зардлыг 153,295.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 124.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг 19,513.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 636,307.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн зардлын дутуу гүйцэтгэл нь коронавируст цар тахлын улмаас эмнэлгээр үйлчлүүлэгчийн тоо буурсан, төлөвлөгөөт хагалгаа зогссон тул эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр хийгдэх эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал 748,292.9 мянган төгрөгөөр, өндөр өртөгтэй мэс заслын зардал 631,506.0 мянган төгрөгөөр, бусад арга хэмжээний зардал 84,226.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал 6,062.8 мянган төгрөгөөр, биеийн тамирын арга хэмжээний зардал 4,050.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төлбөр тусламж, үйлчилгээний нэмэлт орлого 30,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, багаж техник хэрэгслийн зардалд 10,000.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,000.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 18,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бол жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2020 оны төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн оруулаагүй байна. Шилэн дансны хэрэгжилтэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс дотоод хяналт хэрэгжүүлж, зөвлөмж өгөөгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 308,821.5 мянган төгрөгийн 8 зөвлөмж өгсний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 147,153.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,895.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 46,225.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 96,033.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 4,895.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 46,225.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Байгууллагын шилэн дансанд жилийн эцсийн санхүүгийн тайлан болон 5 сая төгрөгөөс дээш 35,141.9 мянган төгрөгийн 3-н гүйлгээг тус тус байршуулаагүй, тайлант оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан "Шилэн дансны зарчим"-ын 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 5 дугаар зүйлийн 5.1-т "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна", 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.1-т "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг шалгагдагч байгууллагад танилцуулсан бөгөөд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

2. Хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад хамааралгүй ажилчдад 11,083.4 мянган төгрөгийн хортой нөхцөлийн нэмэгдэл бодож олгосон, илүү цагаар ажиллуулах хязгаарлалтыг мөрдөж, ажлын цагийг зохистой удирдаагүйгээс 30 гаруй албан хаагчид жилд 500-1220 хүртэл цагаар илүү ажилласан зэрэг нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид

хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журмын 2-т “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д багтсан эрүүл мэндийн ажилтан, эх барих-эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, хүүхэд, нярайн эмч болон сувилагчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно”, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”, Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д “Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна”, 70.3-д “Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна”, 73.2-д “Энэ хуулийн 73.1-д заасан тохиолдолд нэгтгэн бодсон цаг нь тооцоот хугацаанд ногдох ажлын цагийн нийлбэрээс хэтэрч болохгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг шалгаагдагч байгууллагад танилцуулсан бөгөөд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

3. Сахилгын шийтгэлтэй хугацаа дуусаагүй албан хаагчид 4,315.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон, ажилласан хоногийг илүү тооцож 579.6 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан зэрэг нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”, 131 дүгээр зүйлийн 131.4-т “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг шалгаагдагч байгууллагад танилцуулсан бөгөөд төлбөрийн акт тогтоох

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 96,033.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд болоод тайлангийн дараа анхаарал татах бусад чухал асуудал үгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой асуудал

Бараа материалын дансанд 66,259.8 мянган төгрөгийн үнэ бүхий, 49 нэр төрлийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн, Эмнэлгийн тасаг нэгжүүдийн яаралтай тусламжийн бэлэн байдлын нөөцийн эм тарианд нөхөн сэлгэлт хийгээгүйгээс 3,727.2 мянган төгрөгийн эм, тариа урд оны үлдэгдлээр тайлагнагдсан зэрэг нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.30-д "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө: хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тухайн байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай үнэлэх боломжтой", 4.22-т "Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагдах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна" гэсэн заалттай тус тус нийцээгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Хөрөнгийн бүртгэлийн суурь зарчим алдагдах, хөрөнгө үрэгдэх, элэгдлийн зардал дутуу тайлагнагдах, үргүй зардал гарах

1.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгөд бүртгэх, ашиглалтын жил, түүнд хамаарах элэгдлийн зардлыг нөхөн тооцоолж тайлагналын зөрүүг арилгах, нөөцийн эм тарианд тухай бүр сэлгэлт хийх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг буруу тогтоож 21 төрлийн хөрөнгийн элэгдлийн зардлыг 8,038.0 мянган төгрөгөөр илүү тооцсон. Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгөд 4,930.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөхөж байгуулсан нь ТТАХНЭ-ийн захирлын 2020 оны А/151 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн 5-д заасан "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа" болон "Байгууллага нь хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой" гэсэн заалттай нийцээгүй, тохилуулга ба тодруулга, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тогтоосноор төсвийн хөрөнгө оруулалтын зардал өсөх, үр дүнгийн тайлангийн зардал буруу илэрхийлэгдэх, үйл ажиллагааны үр дүн буурах

2.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил, бүртгэл, тайлагналд хяналт тавьж, ашиглалтын хугацаа болон элэгдлийн зардлын тайлагналын зөрүүг арилгах, алдааг давтан гаргахгүй байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

3,953.9 мянган төгрөгийн өглөг, 24.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, тулган баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Харилцагч талтай тооцооны зөрүү үүсэх

3.3. Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийн тооцооны үлдэгдлийг хуулийн хугацаанд баталгаажуулж, акт үйлдэх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Эмблем бүхий энгэрийн читон, тэмдэг, түлхүүрийн оосор худалдан авахад 9,100.0 төгрөгийн үргүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасанд нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

Ковид 19 цар тахлын үед төсвийн орлого буурч, зайлшгүй зардалд төсөв хүрэлцэхгүй болох

4.3. Өгсөн зөвлөмж:

Баяр ёслол, бэлэг дурсгалын болон тэвчиж болох зарим зардлыг бууруулж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

5. Дотоод аудиттай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн болон Төсвийн шууд захирагчийн зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйл-д “Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх”-ийн 16.5.6-д “ дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасанд тус тус нийцэхгүй байна.

5.2. Эрсдэл:

Дотоод хяналтын сул байдлаас алдаа, дутагдал гарах

5.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагаар хангах

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/23/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын шилэн дансанд жилийн эцсийн санхүүгийн тайлан болон 5 сая төгрөгөөс дээш 35,141.9 мянган төгрөгийн 3-н гүйлгээг тус тус байршуулаагүй, тайлант оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдээлээгүй	35,141.9	Албан шаардлага	ТТАХНЭ-ийн захирал, хошууч; Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Х.Бат-Ирээдүй; Д.Гантуяа
2	Хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад хамааралгүй ажилчдад 11,083.4 мянган төгрөгийн хортой нөхцөлийн нэмэгдэл бодож олгосон, илүү цагаар ажиллуулах хязгаарлалтыг мөрдөж, ажлын цагийг зохистой удирдаагүйгээс 30 гаруй албан хаагчид жилд 500-1220 хүртэл цагаар илүү ажилласан	11,083.4	Албан шаардлага	ТТАХНЭ-ийн захирал, хошууч; Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Х.Бат-Ирээдүй; Д.Гантуяа
3	Сахилгын шийтгэлтэй хугацаа дуусаагүй албан хаагчид 4,315.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон, ажилласан хоногийг илүү тооцож 579.6 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан	4,895.0	Акт	ТТАХНЭ-ийн захирал, хошууч; Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Х.Бат-Ирээдүй; Д.Гантуяа
4	66,259.8 мянган төгрөгийн үнэ бүхий, 49 нэр төрлийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, Эмнэлгийн тасаг нэгжүүдийн яаралтай тусламжийн бэлэн байдлын нөөцийн эм тарианд нөхөн сэлгэлт хийгээгүйгээс 3,727.2 мянган төгрөгийн эм, тариа урд оны үлдэгдлээр тайлагнагдсан	69,987.0	Зөвлөмж	ТТАХНЭ-ийн захирал, хошууч; Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Х.Бат-Ирээдүй; Д.Гантуяа
5	Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг буруу тогтоож 21 төрлийн хөрөнгийн элэгдлийн зардлыг 8,038.0 мянган төгрөгөөр илүү тооцсон. Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгөд 4,930.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөхөж байгуулсан	12,968.1	Зөвлөмж	ТТАХНЭ-ийн захирал, хошууч; Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Х.Бат-Ирээдүй; Д.Гантуяа

6	3,953.9 мянган төгрөгийн өглөг, 24.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, тулган баталгаажуулаагүй	3,977.9	Зөвлөмж	ТТАХНЭ-ийн захирал, хошууч; Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Х.Бат-Ирээдүй; Д.Гантуяа
7	Эмблем бүхий энгэрийн читон, тэмдэг, түлхүүрийн оосор худалдан авахад 9,100.0 төгрөгийн үргүй зардал гаргасан	9,100.0	Зөвлөмж	ТТАХНЭ-ийн захирал, хошууч; Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Х.Бат-Ирээдүй; Д.Гантуяа
8	Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн болон Төсвийн шууд захирагчийн зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллаагүй		Зөвлөмж	ТТАХНЭ-ийн захирал, хошууч; Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Х.Бат-Ирээдүй; Д.Гантуяа
ДҮН		147,153.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25 № 09/АД170073
САГ-2021/23/СТА-ТМЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй 9 албан хаагчид 4,315.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон, ажилласан хоногийг илүү тооцож 579.6 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Ажилтны цалин хөлснийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно", 131 дүгээр зүйлийн 131.4-т "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R_Gazar9.Docx


001090405

1. Цалин хөлс, урамшууллын илүү тооцож олгосон 4,895,000.00 /дөрвөн сая, найман зуун ерэн таван мянга/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, хошууч Х.Бат-ирээдүй, Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Д.Гантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Л.МӨНХЦАЦРАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 26/А0170073
САГ-2021/23/СТА-ТЦ13

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансанд жилийн эцсийн санхүүгийн тайлан, 5 сая төгрөгөөс дээш 35,141.9 мянган төгрөгийн 3-н гүйлгээг байршуулаагүй, тайлант оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан "Шилэн дансны зарчим"-ын 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 5 дугаар зүйлийн 5.1-т "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна", 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх татаж авах, хэвлэх боломжтой байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.1-т "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан " Албан

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherem\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R_Gazar\14.Docx

001081066


шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

1. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дээрх алдаа, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, хошууч Х.Бат-ирээдүй, Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Д.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Л.МӨНХЦАЦРАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 27/АДТ-0073

Улаанбаатар хот

САГ-2021/23/СТА-ТЦУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад хамааралгүй ажилчдад 11,083.4 мянган төгрөгийн хортой нөхцөлийн нэмэгдэл олгосон, илүү цагаар ажиллуулах хязгаарлалтыг мөрдөж, ажлын цагийг зохистой удирдаагүйгээс 30 гаруй албан хаагчид жилд 500-1220 хүртэл цагаар илүү ажилласан байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журмын 2-т "Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-д багтсан эрүүл мэндийн ажилтан, эх барих-эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, хүүхэд, нярайн эмч болон сувилагчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно", Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт", Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д "Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна", 70.3-д "Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна", 73.2-д "Энэ хуулийн 73.1-д заасан тохиолдолд нэгтгэн бодсон цаг нь тооцоот хугацаанд ногдох ажлын цагийн нийлбэрээс хэтэрч болохгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R_Gazar\15.Docx

001081069

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан " Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан хаагчдын цалин хөлсний нэмэгдэл, илүү цагийн зохицуулалтай холбоотой дээрх алдаа, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, хошууч Х.Бат-ирээдүй, Санхүү, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Д.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Л.МӨНХЦАЦРАЛ

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the conclusion.

